МОНГОЛ УЛС
**ДАРХАН-УУЛ АЙМАГ**
**ЗАСАГ ДАРГА**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059 Утас: 7037-8023
Факс: 7037-7121, Цахим шуудан: info@darkhan.gov.mn
Цахим хуудас: www.darkhan.gov.mn

2023.06.14 № 1-10/364

танай ____________ -ны № ______________ -т

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗАРТ

Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилтийг нэгтгэн боловсруулж хяналт, шинжилгээ үнэлгээ хийлгэн тайланг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт: 17 хуудастай.

ДАРГА Б.АЗЖАРГАЛ

4523100649

D: ZDTG-2023 toot-1

## МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Журмын 3б хавсралт

| № | Төсөл, арга хэмжээ | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хугацаа | Үндсэн хэрэгжүүлэх байгууллага | Эх үүсвэр | Нийт хөрөнгийн хэмжээ / сая төг/ | Суурь түвшин /2021 он/ | Зорилтот түвшин, үр дүн /хөрөнгийн хэмээ эх үүсвэр/ Зорилтот түвшин /2023он/ | Төсөв / сая. Төг/ | Төсвийн гүйцэтгэл / сая. Төг/ | Хэрэгжилт | Үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| | | | | | | Бүлэг 1.Хүний хөгжлийн бодлого | | | | | | |
| 1 | 1.1.Боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хүүхэд бүрийг тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ. | 1.1.6.5. Суралцагч тухтай орчинд суралцаж, бие бялдар, авьяас чадвараа хөгжүүлэх орчныг бүрдүүлэх / Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангах цэцэрлэг, сургууль, дотуур байрны тоо/ | 2021-2024 | БШУЯам | ОНТХО | 3,000.0 | 4-н сургууль, 3-н цэцэрлэгт хөрөнгө оруулалтын ажил хийгдсэн | 27 сургууль, 40 цэцэрлэг, 3 дотуур байр | 937.0 | 150.0 | Боловсрол- 2032 хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн төсвийн 500.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Дархан сумын 1,4,15, ОИЦ сургуулиудад 4-н төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Дархан сум 1-р сургуулийн спорт заалны засварын ажилд 205.3 сая төгрөг, Дархан сум 4-р сургуульд 2ш Лэд дэлгэц авах ажилд 70.0 сая төгрөг, 15 сургуулийн спорт заалны засварын ажилд 84.7 сая төгрөг, ОИЦ сургуулийн дотуур байрны засварын ажилд шаардагдах материал худалдан авах ажилд 140.0 сая төгрөг зарцуулж байна. Иргэдийн оролцоотой төсөл хөтөлбөрийн хүрээнд Дархан сумын 30,25, 6, 27, 21, 22,7, Орхон сумын 9-р цэцэрлэгүүдэд нийт 160.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар тохижилтын ажил хийж гүйцэтгэж байна. Хонгор су, Шарын гол сумын спорт заалны засвар, шалны засварын ажлуудад 249.0 сая төгрөг зарууж байна. Нарны хүүхдүүд асрамжийн газрын гадна дулааны шугам сүлжээг шинэчлэх ажилд 29.0 сая зарцуулав. | 70% |
| 2 | 1.3 Өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг нэвтрүүлэн, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, | 1.3.1.1. Өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх "Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээний | 2021-2024 | Эрүүл мэндийн яам | Улсын төсөв | 3.0 | Жирэмсний эрт үеийн хяналтын хамрагдалт 94.1% байна. | 30 | 0.0 | 0.0 | Жирэмсний эрт үеийн хяналтын хамрагдалт 98.6% байна. Өмнөх жилтэй харьцуулахад 5,5%-аар өссөн. Жирэмсний хожуу хяналт өмнөх онтой харьцуулах 4,9%-аар буурсан үзүүлэлттэй байна. Мөн эрт үеийн хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор Өрх сумын ЭМТ-ийн эх баригч, эмч нарт "Жирэмсний хяналт" сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 9 тохиолдол 1000 амьд төрөлтөнд 11.4 промилл процент. Урд оны мөн үеэс 4 тохиолдлоор буурсан ч тухайн оны амьд төрсөн нярайд харьцуулахад 8.6‰-оор буурсан сайн үзүүлэлтэй байна. | 50% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хүртээмжийг сайжруулна. | хэрэгжилт, хувиар | | | | | | | | | | |
| 3 | | 1.3.1.2. Өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх "Эрүүл чийрэг эр хүн" арга хэмжээний хэрэгжилт, хувиар | 2021-2024 | Эрүүл мэндийн яам | Улсын төсөв | 0.0 | 51.6 | 75 | 0.0 | 0.0 | •Монгол улсын Эрүүл мэндийн сайдын 2021.09.09-ны өдрийн А/559 дугаар тушаалын дагуу "Эрүүл чийрэг эр хүн" арга хэмжээний 4 зорилтын хүрээнд 17 арга хэмжээний хэрэгжилт 52.7%-тай байна.<br>• ЕБС-ийн 1-12 дугаар ангийн 457 үзлэг хөвгүүдийн үзлэг, МСҮТ-ийн 256 хөвгүүнийг бэлгийн замын халдварын шинжилгээнд хамруулсан байна. цаашид Давтан эмчилгээнд хамрагдах хянагдах шаардлагатай 22 хөвгүүнд ганцаарчилсан зөвлөгөө өгсөн.<br>• Эрүүл чийрэг- Эр хүн" арга хэмжээний хүрээнд Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд сургалтыг Хууль сахиулах байгууллагууд,Зэвсэгт хүчний анги нэгтгэл, ШШГГазар, Онцгой байдлын газар, Цагдаагийн газрын бие бүрэлдэхүүн 8 удаагийн сургалтаар 250 хүн хамрагдсан<br>• Нэгдсэн эмнэлэгт урологийн хагалгааг 23 хүнд хийсэн.Үүнээс дурангийн хагалгааны нэр төрлийг нэмэгдүүлж, шинээр түрүү булчирхайн дурангийн мэс заслыг 5 хүнд, шээдэг сувний нарийсал дурангаар 2 хүнд, цавны ивэрхий дурангаар нөхөх /ТАР/-1 хүнд, өрцний ивэрхий дурангаар нөхөх-1 хүнд хагалгааг амжилттай хийсэн. Эдгэрэлт 100% байна.<br>Арга хэмжээний хэрэгжилт хэрэгжилт 52.7% -тай байна. | 70% |
| 4 | | 1.3.1.3. "Харшлаас сэргийлэх" арга хэмжээний хэрэгжилт, хувиар | 2021-2024 | Эрүүл мэндийн яам | Улсын төсөв | 4.0 | 15 ААНБ-ын 1500 иргэн хамрагдсан. | 50 | 0.0 | 0.0 | Монгол улсын Эрүүл мэндийн сайдын 2021.12.31-ний өдрийн А/816 дугаар тушаалын дагуу "Харшлаас сэргийлэх" арга хэмжээний төлөвлөгөө 4 зорилтын 17 үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж, хэрэгжилт 53.7%-тай байна.<br>•Арьс харшлын өвчнөөс урьдчилан сэргийлье үзлэгийг 24 аж ахуй нэгж албан байгууллага, 5 өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 5381 хүнд зохион байгуулж, арьс харшлын эмчийн үзлэгт 4507 иргэд хамрагдаж, шинэ өвчлөл 87, архаг сэдрэлтэй 168 хүн эмчилгээ хяналтад авсан.<br>•Харшлаас урьдчилан сэргийлье, эмчилгээний үр дүн, хяналтын хугацаа сэдвүүдээр 15 удаагийн сургалтаар 2301 хүн хамрагдаж, мэдлэгийн дундаж түвшинг 25%-иар дээшилсэн. Харшлаас сэргийлэх 5 төрлийн зөвлөмжийг 1000ш тараасан. | 70% |
| 5 | | 1.3.1.4. Өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эрүүл | 2021-2024 | Эрүүл мэндийн яам | Улсын төсөв | 4.0 | 12000 иргэн хамрагдсан | 50 | 0.0 | 0.0 | Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2021.12.31-ний өдрийн А/816 дугаар тушаалын дагуу "Элэг бүтэн Монгол" арга хэмжээний төлөвлөгөө 4 зорилтын 17 үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж, хэрэгжилт | 70% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | амьдралын хэв маягийг төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх "Элэг бүтэн Монгол" арга хэмжээг хэрэгжүүлж, Д вирустэй иргэдийг эмчилгээнд хамруулах ажлын явц, хувиар | | | | | | | | | 53.7%-тай байна.<br>2023 онд В вирусийн халдвартай 6 эхээс төрсөн нярайд хепатитийн В вирусийн эсрэг вакцин 100 хувь хийгдэж В вирусийн эсрэг иммуноглобулин(HB-Ig)–г 6 нярайд хийсэн. В вирусын эсрэг товлолт вакцины хамрагдалт 99.9% байна. В вирусын эсрэг сайн дурын дархлаажуулалтад 1359 хүн 3 тун вакцинаа бүрэн хийлгэсэн байна. Нийт 236 эмч эмнэлгийн ажилтнуудад сайн дурын В вирусийн эсрэг вакцин 3 тунгаар хийгдсэн байна..<br>В, С вирусийн шинжилгээнд 15-аас дээш насны 4481 хүн буюу 30%-тай. хамрагдсан. Үүнээс В вирус илэрсэн иргэдээс ачаалал тоолох шинжилгээнд 32 илгээж 17 идэвхжилтэй идэвхгүй 15 байна. С вирусийн эсрэг эмчилгээнд 17 хүн хамрагдаж, 17 хүнд эмчилгээний үр дүн гарсан. Эмчилгээний үр дүн 82.4 хувь байна.<br>В, С вирусийн идэвхжил тоолох шинжилгээг 1112 хүнд хийснээс В-тоолох 615, С – тоолох шинжилгээнд 467 хүн хамрагдсан байна. Үүнээс В идэвхтэй-282, идэвхигүй-178, С идэвхтэй-198, идэвхгүй-225 байна. Д илрүүлэг шинжилгээг 289 иргэнд хийснээс ачаалал тоолох шинжилгээнд 53 хүн хамрагдсан байна. | |
| 6 | | 1.3.1.5 Өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх "Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх" арга хэмжээний хэрэгжилт, хувиар | 2021-2024 | Эрүүл мэндийн яам | Улсын төсөв | 4.0 | 6 чиглэлийн сургалт зохион байгуулсан | 30 | 0.0 | 0.0 | Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2022.10.31-ний өдрийн А/780 дугаар тушаалын дагуу "Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх" арга хэмжээний төлөвлөгөө 7 зорилтын 45 арга хэмжээний хэрэгжилт 58%-тай байна.<br>2023 оны 20-р долоо хоногийн томуугийн матриц үнэлгээгээр ТТӨ – 35.7, АЗЦХХ- 5.2 буюу УЛИРАЛ ХООРОНДЫН ҮЕ дээр байна. 19 дүгээр долоо хоногтой харьцуулахад эмнэлэгт хэвтэлт 0.1 промиль өсч, амбулаторийн өвчлөл 0.6 промиль буурсан. 0-15 насны хүүхдийн товлолын дархлаажуулалтад хамрагдвал зохих 8561 хүүхдээс 8556 хүүхэд хамрагдаж 99.9%-тай байна. ВГВ-ын эсрэг дархлаажуулалтыг төрсний дараа 24 цагийн дотор нийт 680 хүүхдэд, Гепатит В вирусийн халдвартай эхээс төрсөн 14 нярайд гепатит В вирусын эсрэг иммуноглобулиныг хийсэн байна.<br>Тархвар судлалын заалтаар: Галзуу өвчний эсрэг дархлаажуулалтыг нийт 139 хүнд хийсэн. Үүнээс:1-р тун 106, 2-р тун 58, 3-р тун 53. Хачигт халдвараас сэргийлэх дархлаажуулалтыг 182 хүнд хийсэн.<br>2023 оны эхний хагас жилийн байдлаар БЗДХ-ын өвчлөлийн шинэ 96 тохиолдлыг илрүүлэн 100% эмчлэн хяналтад авсан. Үүний үр дүнд 32 удаа 4389 иргэдийг хамруулж илэрсэн шинэ өвчлөл бүртгэгдэн | 70% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | 100% эмчлэн эрүүлжүүлж хяналтанд авсан. 2023 оны 5 сарын байдлаар Сүрьеэ шинэ 45, дахилтат 12. ЭТС-2 бүртгэгдсэн Нийт 59. 2022 онтой харьцуулахад шинэ 6, ЭТС 2- оор буурч дахилт 5 тохиолдлоор нэмэгдсэн. Хяналтад 82 эмчлэгдэж байна. | |
| 7 | | 1.3.1.6.Өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх "Хавдрын эсрэг" арга хэмжээний хэрэгжилт, хувиар | 2021-2024 | Эрүүл мэндийн яам | Улсын төсөв | 3.0 | 4352 хүн эрт илрүүлэгт хамрагдсан. | 50 | 0.0 | 0.0 | Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2021.06.10-ны өдрийн А/360 дугаар тушаалын дагуу "Хавдрын эсрэг" арга хэмжээний төлөвлөгөө 5 зорилтын хүрээнд 51 арга хэмжээний хэрэгжилт 48.7%-тай байна.<br>• Хавдар судлалын үндэсний төв, Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран Хөнгөвчлөх эмчилгээ, өвдөлт намдаах тусламжийн сургалт зохион байгуулж, 50 эмч эмнэлгийн мэргэжилтэнг хамруулсан. Монгол орон даяар үндэсний хэмжээнд "Амьдрал бэлэг" төслийн хүрээнд элгээ хайрладаг хүн бүрт зориулсан урьдчилан сэргийлэх үзлэг, эрүүл мэндийн өдөрлөг зохион байгуулж, 200 гаруй иргэдийг хамруулсан.<br>• Хавдар судлалын үндэсний төв, Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран Хөнгөвчлөх эмчилгээ, өвдөлт намдаах, хорт хавдраас урьдчилан сэргийлэх, хянах бодлого, түүний хэрэгжилт, Хөнгөвчлөх тусламж үйлчилгээ түүний ойлголт, хими эмчилгээ, хавдрын хожуу үеийн хөнгөвчлөх тусламж үйлчилгээ сэдвүүдээр Залуучууд театрт сургалтыг эрүүл мэндийн байгууллагуудын Эрүүл мэндийн газрын удирдлагууд болон Нэгдсэн эмнэлэг, Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүд нийт 50 эмч хамруулан зохион байгуулсан. Залуучууд театрын бага танхимын гадна талбайд Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, Нэгдсэн эмнэлэг, анхан шатны байгууллагууд, эмийн байгууллагууд хамтран "Элэгний хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг, оношлогоо,эмчилгээ, даатгалаас олгох хөнгөлөлтэй эм" сэдвээр иргэдэд чиглэсэн нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулж, Элэгний вирустэй, хатууралтай хавдартай хяналтын 200 гаруй иргэд хамрагдсан.<br>• Эрүүл мэндийн газраас "Хавдрын эсрэг арга хэмжээг хэрэгжүүлье - Эмч бүр хавдрын эсрэг хувь нэмрээ оруулья" Эрүүл мэндийн салбарын хэмжээнд болзолт уралдааныг " 4-р сарын 17-ноос 6-р сарын 17-ны өдөр хүртэл зохион байгуулж байна.<br>• Нэгдсэн эмнэлгийн хавдрын хөнгөвчлөхийн тасагт 247 хүн хэвтсэн. Хөнгөвчлөх -236 хүн, хавдар-11 хүн, хими эмчилгээнд 9 хүн давхардсан тоогоор 49 удаа, хавдрын | 70% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | хагалгаа ороогүй. | |
| 8 | | 1.3.2.8 Орчин үеийн стандартад нийцсэн эмнэлгийн тоог нэмэгдүүлж, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах. Шинээр барих болон өргөтгөх нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвийн тоо | 2022-2024 | Эрүүл мэндийн яам | Улсын төсөв | 3,000.0 | Хүүхдийн эмнэлгийн барилгын их засвар хийгдсэн | 40 | 0.0 | 0.0 | 1. Дархан-Уул аймагт Эрүүл мэндийн төв 1, Нэгдсэн эмнэлэг 1, Өрхийн эмнэлэг 5, Сумдын Эрүүл мэндийн 3-н төв үйл ажиллагаа явуулж байна.<br>50 ортой төрөх эмнэлэгт жилд дунджаар 1200-1500 эх амаржиж байна. Төрөх эмнэлэг нь нийт хүчин чадлын 60%-70% ашиглаж байна. Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд Дархан-Уул аймгийн хүн ам механикаар 20% өсөж 2024 онд 127.0 мянган хүн амтай байхаар тооцоо гарсан. Иймд аймгийн Нэгдсэн эмнэлгийг стандартад нийцсэн орчин үеийн эмнэлэг барих ажлыг Европын сэргээлт босголт банкны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлнэ. Эмнэлгийн өргөтгөл барих 5га газрын аймгийн Нэгдсэн эмнэлэгт олгосон. Европын сэргээлт босголт банкнаас ТЭЗҮ боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж байна.<br>2. Монгол Улсын 2024 оны төсвийн хөрөнгө оруулалтын төсвийн төсөлд "Амин холбоо", "Гэрэлтэй", МЭДС ТОБ" өрхийн эмнэлгийн өргөтгөл барих төслийг тусгуулахаар саналыг Эрүүл мэндийн яаманд хүргүүлээд байна. | 30% |
| 9 | 1.6. Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, үндэсний онцлогийг агуулсан соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлнэ. | 1.6.1.1. Үндэсний бахархал, өв соёлыг сурталчлан таниулж, үндэсний онцлогийг агуулсан соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих /"Соёлын бүтээлч үйлдвэрлэл-I" арга хэмжээний хэрэгжилт, хувиар/ | 2021-2024 | Соёлын яам | Улсын төсөв | 10.0 | 50 | 80 | 3.0 | 0.0 | "Соёлын бүтээлч үйлдвэрлэл-II" аяны хүрээнд дараах 9 арга хэмжээг зохион байгуулж ажиллалаа. Үүнд:<br>1. Соёл урлагийн газраас ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад "Өв соёлоо өвлөн уламжилъя" зүү ороох хаттамлын сургалтыг зохион байгуулсан. Энэ өргөжүүлж Эмэгтэйчүүдийн холбоотой хамтран төсөл хэрэгжүүлж байна.<br>2. "Цагаан сар 2023" үзэсгэлэн худалдаанд урчууд болон соёлын бүтээлч үйлдвэрлэгч 3 иргэн, аж ахуйн нэгж оролцож өөрсдийн бүтээлээ сурталчиллаа.<br>3. Шарын голын сумын Соёлын төвөөс санаачлан сумын эмэгтэйчүүдийн холбоотой хамтран "Үзэсгэлэнт" өглөөлгийг зохион байгуулсан. Тус өдөрлөгийг жил бүр брэнд болгон хэвшүүлэхээр зорин ажиллаж байна.<br>4. УБ хотноо 2 дахь жилдээ зохион байгуулагдсан Үнэт эдлэл, Соёлын өвийн хосгүй бүтээлүүд, Гоёл чимэглэлийн салбарын нэгдсэн үзэсгэлэнд Дарханы урчууд амжилттай оролцож 4 уран | 100% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | бүтээлчийн 11 бүтээлийг олон нийтэд сурталчилсан.<br>5. "ART FAIR 2023" дүрслэх урлагийн үзэсгэлэн худалдаанд Дарханы Зураач урчуудын эвлэлийн 4 зураач нийт 11 бүтээлээр оролцлоо.<br>7. Евро Азийн соёл, урлагийн нийгэмлэг, Монголын урчуудын эвлэлийн удирдах зөвлөлөөс Дарханы зураач урчуудын эвлэлийн залуу уран бүтээлчидтэй уулзаж, цаашдын уран бүтээлийн хамтын ажиллагаа Дархан хотод дүрслэх урлагийг хөгжүүлэх тухай асуудлаар санал бодлоо солилцлоо.<br>8. Соёл, урлагийг дэмжих сангаас зарласан төслийн сонгон шалгаруулалтад Дархан-Уул аймгаас 2 уран бүтээлч оролцож, **"Найрамдлын Дархан хот"** монгол зураг шинээр бүтээх төсөл, **"Сүбээдэй Баатар"** туульсын зохиолын ном хэвлэх төслүүд тус тус шалгарсан.<br>9. Соёлын бүтээлч үйлдвэрлэгч-дийн үзэсгэлэнд "Цайны их зам" ХХК Англи, Австрали, Ковбой загварын Монгол морины хэмжээнд тааруулж хийсэн ШИРМЭЛ эмээл болон өдөр тутмын хэрэглээнд зориулсан бүх төрлийн эмээлээр оролцлоо. | |
| 10 | | 1.6.2.4. Үндэсний бахархал, өв соёлыг сурталчлан таниулж, үндэсний онцлогийг агуулсан соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих / Ашиглалтад орох соёл урлагийн байгууламж, музей болон номын сангийн тоо/ | 2022-2024 | Соёлын яам | Улсын төсөв | 15,400.0 | Барилгын ажил 22% | Барилгын ажил 60% | 2,400.0 | 0.0 | 1. Музей, номын сангийн цогцолбор барилгын ажлын талаар Соёлын яамнаас барилгын захиалагч, гүйцэтгэгч талуудыг байлцуулан 2 удаа цахимаар хуралдаж, удирдах дээд байгууллагаас томилогдсон ажлын хэсэг барилгын явцтай газар дээр нь 3 удаа ирж танилцан үүрэг чиглэл өгч ажилласан.<br>2. Музей, номын сангийн цогцолбор барилгын ажил 2023 оны эхний 5 сарын байдлаар зоорийн давхрын 24 см тоосгон өрлөгийн ажил, 1 давхрын гадна ханын 36 см-ийн блокийн өрлөг, 2-р давхрын угсралтын ажлууд хийгдэж байна.<br>Музей, номын сангийн цогцолборын барилгын ажил 35 хувьтай. | 30% |
| **Бүлэг 2.Эдийн засгийн бодлого** | | | | | | | | | | | | |
| 11 | 2.5.Хөдөө аж ахуйн гол нэрийн 19 бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, импортыг орлох болон экспортын баримжаатай | 2.5.1.2. Малын гаралтай түүхий эдийн боловсруулалтын түвшинийг нэмэгдүүлэх үйлдвэрлэл технологийн паркуудыг байгуулах /"Дархан | | | | | | | 2,000.0 | | Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар "Дархан арьс ширний цогцолбор" үйлдвэрийг байгуулж байгаа бөгөөд тус үйлдвэр ашиглалтад орсноор 7500 орчим байнгын ажлын байр шинээр бие болж жилдээ 10 сая ширхэг арьс шир боловсруулах 13 үйлдвэр, 10 мянган тонн ноос боловсруулах ноос, ноолуур угаах самнах үйлдвэр, түүний цэвэрлэх байгууламж, инженерийн дэд бүтцийн | 50% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжиж, хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдэд суурилсан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлнэ. | арьс ширний цогцолбор" үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын явц, хувиар/ | 2021-2024 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам | Гадаадын хөрөнгө оруулалт | 107,000.0 | Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 30 хувьтай байна. | Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 70 хувьд хүрсэн байна | | 0.0 | барилга байгууламж бий болно. 2023 оны эхний хагас жилийн байдлаар эрчим хүч, усан хангамж, бохир ус цэвэрлэх байгууламж, дулаан хангамж, уурын зуух зэргийг барьж байгуулахад 15.4 сая.ам долларын хөрөнгө оруулалтын ажил хийгдэж, эрчим хүч 95% гүйцэтгэлтэй, дэд станц шинээр барих ажил 90% гүйцэтгэлтэй, ус, дулаан хангамжийн ажил 70% гүйцэтгэлтэй, бохир ус цэвэрлэх байгууламжийн аэро-танк-н ажил 100% хийгдсэн хийгдэж уур үүсгэгч талбайн ажлын барилга угсралтын ажил хийгдсэн. | |
| 12 | | 2.6.2.1. "Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл I"-ийн бүтээн байгуулалтын ажлын явц, хувиар | 2021-2024 | | | - | 30 | 70 | - | 0.0 | Европын холбооны санхүүжилттэй "Найрамдал" төслийн III зорилтын хүрээнд Европ-Дарханы инноваци, энтрепренершип төвтэй хамтран "Уур амьсгалын нөхцөлд тохирсон ухаалаг газар тариалан ба агропренершип" чадавхжуулах талбайн дадлага буюу туршлага судлах тусгай сонирхлын аялалд 35 өрхийн хүнсний ногоо тариалагчид болон хоршоод, оролцож, газрын гүний дулаан ашигласан өвлийн хүлэмж барих аргачлал, ажиллах зарчим болон агро аялал жуулчлалтай танилцууллаа | 100% |
| 13 | 2.6. Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ. | 2.6.2.2. "Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл II"-ийн бүтээн байгуулалтын ажлын явц, хувиар | 2021-2024 | Байгаль орчин, аялал жуулчлалын яам | Гадаадын зээл, тусламж | - | - | 30 | 29,000.0 | 0.0 | Европын Холбооны санхүүжилттэй НАЙРАМДАЛ төслийн хүрээнд НАЙРАМДАЛ төсөл, аймгийн ЗДТГ, Байгаль орчин аялал жуулчлалын газар хамтран "Тогтвортой аялал жуулчлал" чадавхжуулах сургалт 4 дүгээр сарын 6,7-ны өдрүүдэд аймгийн ЗДТГ тахимаар зохион байгуулагдсан. Сургалтад төрийн байгууллага, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аялал жуулчлалын холбоо, Зочид буудал, зоогийн газар, жуулчны бааз, амралт сувилал, бусад холбоодын төлөөлөл, тур оператор, шинээр үйл ажиллагаа эрхлэх хүсэлтэй иргэд нийт 70 ААНБ, иргэд хамрагдсан. Сургалтаар Монгол болон Словени улсын шилдэг зөвлөх, мэргэжилтэн, энтрепренерүүд аялал жуулчлалын салбарт дэвшүүлэх шинэ бүтээгдэхүүний санал, төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн түншлэлээр аялал жуулчлалыг хөгжүүлэх болон дэлхийн жижиг хотуудад аялал жуулчлалыг хөгжүүлсэн туршлагыг танилцуулж санал солилцлоо.<br>"Тогтвортой аялал жуулчлал" хөгжүүлэхэд гарц шийдэл эрэлхийлэх сургалт, аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах өдөрлөгийг 04-р сарын 08-ны ДАРХАН 50 цогцолборт зохион байгуулж, | 100% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | Дугуйн холбоо, Мастер тогоочдын холбоо, Дархан Загасчлалын холбоо, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Жижиг дунд бизнесийг дэмжих төв, Дархан Аялал жуулчлалын холбоод, Данс дүүрэн ХХК,Sky зочид буудал, Цайны их зам ХХК өөрсдийн бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлан таниулах үйл ажиллагааг зохион байгуулан оролцлоо. | |
| **Бүлэг 4.Байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах ногоон хөгжлийн бодлого** | | | | | | | | | | | | |
| 14 | 4.1. Ногоон хөгжлийн сэргэлтийг эрчимжүүлэх хүрээнд байгалийн нөөц, баялгийг зүй зохистой ашиглаж, хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулан иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ. | 4.1.1.1. Ойжуулах, байгалийн сэргэн ургалтыг дэмжих, ойн хомстол, доройтлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх /"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд ойжуулах талбайн хэмжээ, мянган га/ | 2021 - 2024 | Байгаль орчин, аялал жуулчлалын яам | Улсын төсөв | 1,000,0 | 4.9 | 9 | 72.0 | 20.0 | Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний 12,0 сая.төгрөгийн зардлаар Хонгор сумын Шивэртэд 10 га талбайд шинэс, нарс төрлийн 3-4 настай 25000 ширхэг тарьцаар ойжуулалтын ажил гүйцэтгэсэн байна. Хонгор сумын байгаль хамгаалагч Д.Наранхүү газар дээр үзлэг хийж, хяналт тавьж ажиллалаа.<br>Хонгор сумын орон нутгийн төсвийн 60,0 сая.төгрөгийн зардлаар 48 га талбайд шилмүүст модны ойжуулалтын ажил хийгдэж байна. | 100% |
| 15 | | 4.1.1.2. Ойн хөнөөлт шавж, өвчний голомттой тэмцэх талбайн хэмжээ, мянган га | 2021 - 2024 | | | 22.8 | 33.9 | 82000га | 5.7 | 0.0 | Эрх шилжүүлэх тухай аймгийн Засаг даргын 2023.03.01-ны өдрийн 01-А/42 тоот захирамжийн дагуу аймгийн хэмжээнд ойн хөнөөлт шавжийн тархалтын тоймчилсон судалгаа хийх зөвлөх үйлчилгээний техникийн тодорхойлолтыг боловсруулж байгууллагын цахим хаяг, вэб хуудсанд байршуулан ажлын хэсгийн хурлаар шалгарсан "Мөнх ногоон жодоо" ХХК-тай гэрээ байгуулсан. Гэрээ ажлын үе шатны төлөвлөгөөний дагуу 6-р сарын 15-наас 82000 га-д судалгааны ажил хийхээр бэлтгэл ханган ажиллаж байна. | 50% |
| 16 | | 4.1.1.3. Ой зохион байгуулалт хийх талбайн хэмжээ, мянган га | 2021 - 2024 | | | 20.0 | 1,600 | 1,800 | 5.0 | 0.0 | Ойн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т заасан хугацаа буюу 2023 онд улсын зардлаар 81997 га ой зохион байгуулалтын ажил хийгдэхээр тендер шалгаруулалтын ажил явагдаж байна. | 30% |
| 17 | | 4.1.1.4. Ойн арчилгаа, цэвэрлэгээ хийх талбайн хэмжээ, мянган га | 2021-2024 | | | 20.0 | 32га | 36.0 | 1.0 | 0.0 | 2022 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн "Иргэдийн индэр" нэлттэй хэлэлцүүлгээс гарсан саналын дагуу аймгийн хэмжээнд ойд арчилгаа, цэвэрлэгээний ажлаар хэрэглээний мод бэлтгэлийн ажлыг аймгийн Засаг дарга 5 жилийн хугацаанд хориглосон шийдвэр гаргасантай холбоотой үйл ажиллагааг зогсоосон.<br>Иргэд ойн цэвэрлэгээний ажлаар түлээний зориулалтаар 136га ойг цэвэрлэж 242 м.куб мод цэвэрлэж 1.2 сая.төгрөгийн төлбөрийг ойн нөөц ашигласны төлбөрийг төвлөрүүлсэн | 30% |
| 18 | | 4.1.3. Уул | | Уул уурхай, | БОХНСА | | | | | | 2023 онд аймгийн хэмжээнд Байгаль орчныг | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээх / Нөхөн сэргээх талбайн хэмжээ, мянган га/ | 2021-2024 | хүнд үйлдвэрийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам | ХЗ | 160.0 | 129га | 2 | 60.0 | 0.0 | хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 3га газар техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийхээр Шарын гол сумаас ирүүлсэн газрын саналын дагуу техникийн тодорхойлолтыг боловсруулан ажлыг гүйцэтгүүлэхээр БОАЖГ-аас 4 удаа зарласан боловч 1 оролцогчоос төсөвт өртгөөс 47 хувиар илүү үнийн санал ирж шаардлага хангаагүй. | 70% |
| 19 | | 4.1.4. Цөлжилтийг сааруулах, элсний нүүлтээс хамгаалах, хамгаалалтын зурвас байгуулах / Цөлжилтийг сааруулах арга хэмжээг хэрэгжүүлэх талбайн хэмжээ, га/ | 2021-2024 | Байгаль орчин, аялал жуулчлалын яам | Улсын төсөв | 178.0 | 4га | 16га | 44.5 | 20.0 | Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний 445 сая.төгрөгийн хөрөнгө оруулалтаар Орхон сумын Шарын адаг 2 га, Хонгор сумын Цагаан нуур орчмын Хүйтний голд 2 га талбайд талбайд 1,0-1,2 м өндөртэй бургас төрлийн 3200 ширхэг модны суулгацаар цөлжилт, элсний нүүдлээс хамгаалах ойн зурвас байгуулах ажлыг "Тэнгэрлэг ой" ХХК гүйцэтгэсэн.<br>Ойн зурвас байгуулсан талбайг 2 м модон шон бүхий 10 х 10 хэмжээтэй тороор бүрэн хашаажуулсан. Хашааны доогуур нэмэлтээр туулай, мэрэгч амьтан орохоос хамгаалсан тор татсан. Усалгааг голоос зөөврөөр нэг удаа усалгаа хийгдсэн. | 100% |
| 20 | | 4.1.5. Хүн амын унд, ахуйн ус хангамжийн нөөц тогтоох хайгуул судалгаа хийх /Нөөц тогтоох сумын төвийн тоо/ | 2023 | Байгаль орчин, аялал жуулчлалын яам | Улсын төсөв | 5.0 | 2 | 1 | 5.1 | 2.0 | Шарын гол суманд 2019 онд буянтын эх үүсвэрийн усны нөөцийг тогтоох газрын доорх усны эрэл хайгуулын ажил хийгдэж БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны А/489 дугаар тушаалаар усны нөөцийг шинэчлэн тогтоосон | 100% |
| **Бүлэг 5.Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого** | | | | | | | | | | | | |
| 21 | Зорилго 5.2.Бүс, орон нутгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн орон нутаг дахь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ. | 5.2.1.2. Орон нутаг дахь сум, суурин газрын ус хангамж, ариутгах татуурга, инженерийн шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх / "Сумын хөгжил" арга хэмжээний хүрээнд инженерийн дэд бүтэц байгуулах сумын тоо/ | 2021-2024 | Барилга, хот байгуулал-тын яам | Улсын төсөв | 19,051.7 | 5 | Төв цэвэрлэх 2 байгууламж, цэвэр усны 15 байршилд шугамын шинэчлэлт хийсэн байна. | 17,567.7 | 5,000.0 | 1.Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН 3244/3245 төсөл нь үндсэн 3 бүрэлдэхүүн хэсэгтэй. 1.А1 багцын гүйцэтгэл 85%-тай, 2. А2 багцын гүйцэтгэл 91%-тай, 3. А3 багцын гүйцэтгэл 94%-ийн гүйцэтгэлтэй. Төслийн хэмжээнд нийт гүйцэтгэл 90.3%-тай байна. Пфайфер Эмит түншлэлтэй 2022 оны 06 сард гэрээ цуцалж 2022 оны 10 сарын 26 өдөр Байгууламж ХХК-тай төслийн үлдэгдэл ажлыг хийж дуусгах шинэчилсэн гэрээг 12,926.0 сая төгрөгний үнийн дүнтэйгээр гэрээ байгуулсан. Нийт бетон цутгалтын **98%** хийгдсэн. Хийц бүтээц арматурчлалын **97%** угсрагдсан. Тоног төхөөрөмж угсралтын **45%** хийгдсэн. Технологийн шугам хоолой угсралтын **70%** хийгдсэн. Буцаан булалт дүүргэлтийн ажил 65%-ийн гүйцэтгэлтэй. Цахилгаан, механик тоног төхөөрөмж худалдан авалтын **85%** төслийн талбайд нийлүүлэгдсэн.<br>2. Дархан хотын төв цэвэр усны шугам хоолойн шинэчлэлтийн ажлыг 15 байршилт | 50% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | хийх ажлыг 5,586.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэж байна. Ажлын гүйцэтгэл 20% гүйцэтгэлтэй байна. 2023 оны 9 сард тус төлийг бүрэн дуусгах төлөвлөгөөтэй ажиллаж байна.<br><br>2. Дархан-Уул аймгийн Хонгор суманд Цэвэрлэх байгууламжийн шинэчлэлтийн ажлыг 539.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2022-2023 онд хийж гүйцэтгэж байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн.<br>3. Орхон, Шарын гол сумдын төв цэвэрлэх байгууламжийн зураг, төсөв боловсруулагдаж Магадлал хийгдсэн. Монгол Улсын 2024 оны төсвийн хөрөнгө оруулалтын төсвийн төсөлд тусгуулахаар саналыг Барилга хот байгуулатын яаманд хүргүүлсэн. Тус төслүүдийн нийт төсөвт өртөг 5,904.9 сая төгрөг. | |
| 22 | | 5.2.1.3 Орон нутаг дахь сум, суурин газрын ус хангамж, ариутгах татуурга, инженерийн шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх Инженерийн шугам, үерийн ус зайлуулах шугам, цэвэр бохир усны шугам сүлжээг шинэчлэх, өргөтгөх ажлын явц, хувиар | 2022-2023 | Барилга, хот байгуулал-тын яам | Улсын төсөв | 63,121.9 | 63,121.9 | 100% | 60,100.0 | 4,570.0 | 1. 2021-2022 онд Орхон сумын төвийн цэвэрлэх байгууламжийн зураг төслийг "Их мянган инженерчлэл" ХХК 45.0сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэж Барилгын хөгжлийн төвөөр хянуулж магадлал хийгдсэн. 2024 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсвийн төсөлд тусгуулахаар саналыг Барилга хот байгуулалтын яам, Сангийн яамны "PIMIS" цахим мэдээллийн санд байршуулсан.<br>Орхон сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2023 онд хийхээр төлөвлөсөн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зураг, төслийн ажлын даалгаврыг боловсруулах ажил хийгдсэн.<br>"Сумын хөгжил" арга хэмжээний хүрээнд Шарын гол сумын Дархан баг чиглэлийн дулааны шугамын өргөтгөлийн ажлыг 941.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Ф159, 219, 273мм хэмжээтэй 730урт /хос метр шугамын өргөтгөл шинэчлэлтийн ажлыг хийгдэж 2023 оны 09 дүгээр сард бүрэн ашиглалтад оруулна . Ингэснээр шинээр үүссэн 72 айлын амины орон сууцны хорооллын дулааны эрчим хүчээр хангах боломж бүрдэнэ.<br>2.Үерийн ус зайлуулах суваг хоолой шинээр хийх ажлыг Дархан сумын 6,8,15-р багт нийт 6 төсөл хэрэгжүүлэхэд 4,380.5 сая төгрөг зарцуулж байна. 2023 оны 9 сард бүрэн ашиглалтад оруулна.<br>3. Дархан-Уул аймагт шинэ суурьшлын бүс болох "Залуус хороолол 1, 2" төслийг Улсын төсвийн 47.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэхээр 2022 оны төсөвт хөрөнгийн эх үүсвэр батлагдсан. Аймаг орон нутгаас ТЭЗҮ, Зураг, төсөв боловсруулах ажлын даалгаврыг 127га талбайд хийж Барилга | 50% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | хот байгуулалтын яаманд хүргүүлсэн. Уг төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах /Зөвлөх болон барилга угсралт/ ажил БХБЯаманд хийгдэж 10 багц ажлаас 8 багц ажлын гүйцэтгэгч шалгарч гэрээ байгуулан зураг, төсөв боловсруулах ажил хийгдэж байна.<br>Тус төсөл хэрэгжсэнээр Залуус хорооллын 127га талбайд эхний ээлжийн 10.0 мянган айлын орон сууц шинээр барих ажлыг бэлтгэл ажил бүрэн хангагдана.<br>3. Дулаан Дамжуулах сүлжээний ТК.27-ТК.39 худгийн хооронд дулааны магистрал шугамын өргөтгөл, их засварын ажлыг 8.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэж байна. 2023 оны 9-р сард бүрэн ашиглалтад оруулна Ажлын гүйцэтгэл 50% биелэлтэй.<br>Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу Дархан сумын 5, 6-р багт дахин төлөвлөлтийн хүрээнд барилгажилтын ажлыг Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд үргэлжлүүлэн хэрэгжүүлэх боломж бүрдэж 42 айлыг төвлөрсөн дэд бүтцэд холбосон.<br>3. ТК80-ТК94 хүртэлх дулааны шугамын шинэчлэлтийн ажлыг Улсын төсвийн 2.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 100 хувийн биелэлттэй. | |
| 23 | | 5.2.3.2. Сум, суурин доторх авто зам, хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламж, гудамж гэрэлтүүлгийн хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн тав тухтай амьдрах орчныг сайжруулах / Сум, суурин доторх гудамж, талбайн тохижилт хийх ажлын явц, хувиар/ | 2021-2023 | Барилга, хот байгуулал-тын яам | Улсын төсөв, ОНТХО | 69,767.8 | 1100ш гэрэлтүүлэг шинээр суурилуулсан. | 41.1км хатуу хучилттай авто зам ашиглалтад оруулна. | 66,767.8 | 1,548.6 | 1.Дархан-Уул аймагт авто замын салбарт Улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 53.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 23 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж байна. Нийт 41.1 км хатуу хучилттай авто зам, төмөр бетон 2ш гүүр, явган хүний нэг гүүрийг ашиглалтад оруулахаар ажиллаж байна.<br>2. Дархан хотын сургуулийн өмнөх боловсролын 7 байгууллагын гадна тохижилтын ажилд 136.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж байна. Дархан сум 8-р баг Гэрлэх ёслолын ордны гадна тохижилтын ажилд 100.0 сая төгрөг зарцуулж байна. Хаврын мод тарилт ногоон байгууламжийн ажлыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 264.0 мянган мод тарьсан бол Ногоон Дархан-2032 хөтөлбөрийн хүрээнд хүрээнд 4641у/м ногоон байгууламжийн хашаа 3-н байршилд барих ажилд 300.0 сая төгрөг зарцуулж байна.<br>3. Дархан сумын гэр хорооллыг 100 хувь гэрэлтүүлэгтэй болгох ажилд 5460ш гэрэлтүүлгийг 12 байршилд суурилуулахад 12,000.0 сая төгрөг зарцуулж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 35% биелэлтэй.<br>Хотын доторх төв авто зам дагуу 15 төсөл хэрэгжүүлж байна. | 30% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | Орон сууцны фасадын 28711метр гэрэлтүүлгийг 1,567.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 98 байранд хийж гүйцэтгэж байна. | |

ТАНИЛЦСАН:

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Б.АЗЖАРГАЛ

ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАСАН:

ХБТХОХ-ИЙН ДАРГА П.БАТСҮХ

ХЭРЭГЖИЛТ НЭГТГЭЖ, БОЛОВСРУУЛСАН

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГЧ Б.БАТСҮХ

## МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА /арга хэмжээгээр/

2023.06.14 Дархан-Уул аймаг

| № | Бүлэг / Үнэлгээ | | Бүгд | Бүлэг, үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | I. Хүний хөгжлийн бодлого | II. Эдийн засгийн бодлого | IV. Ногоон хөгжлийн бодлого | V. Орон нутгийн хөгжлийн бодлого |
| 1. | Зорилгын тоо | | **7** | **3** | **2** | **1** | **1** |
| 2. | Арга хэмжээний тоо | | **23** | **10** | **3** | **7** | **3** |
| 3. | Үүнээс | 100.0% | **7** | 5 | - | 2 | - |
| | | 90.0% | **1** | 1 | - | - | - |
| | | 70.0% | **5** | 1 | 1 | - | 3 |
| | | 50.0% | **3** | 1 | 2 | - | - |
| | | 30.0% | **7** | 2 | - | 5 | - |
| **Хэрэгжилтийн дундаж хувь, оноо** | | | **65.22% буюу 3.26 оноо** | **77.0% буюу 3.85 оноо** | **56.66% буюу 2.83 оноо** | **50.0% буюу 2.5 оноо** | **70.0% буюу 3.5 оноо** |

ТАНИЛЦСАН:
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА Б.АЗЖАРГАЛ

ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА П.БАЯРСАЙХАН

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН О.МӨНХСҮРЭН

# МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

2023.06.14

## Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

"Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө"-ний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, зорилт, арга хэмжээг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

## Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үндэслэл, арга зүй

Засгийн газрын 2021 оны 374 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсээс нэгтгэж ирүүлсэн "Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт"-ийн үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ.

Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэхдээ "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6 дугаар бүлгийн 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалын дагуу арга хэмжээний хүрсэн түвшинг хүрэх түвшинд харьцуулан хувиар, зорилтын хэрэгжилтийг энэ журмын 6.2.3-т заасан аргачлалын дагуу тооцож, арга хэмжээний дундаж үнэлгээгээр 4 ангилалд шилжүүлэн тооцлоо.

## Гурав. Дүгнэлт

"Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө"-ний хэрэгжилтийн

Нэг. Хүний хөгжлийн бодлогын хүрээнд 10 арга хэмжээ,

Хоёр. Эдийн засгийн бодлогын хүрээнд 3 арга хэмжээ,

Дөрөв. Ногоон хөгжлийн бодлогын хүрээнд 7 арга хэмжээ,

Тав. Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын хүрээнд 3 арга хэмжээ,

нийт 4 бодлогын хүрээнд **23** арга хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд ерөнхий үнэлгээ арга хэмжээгээр **65.22%** буюу **3.26 оноо**-гоор үнэлэгдлээ.

- “Үр дүнтэй” буюу 100% үнэлгээтэй 7 арга хэмжээ,

- “Тодорхой үр дүнд хүрсэн” буюу 90-70% үнэлгээтэй 6 арга хэмжээ,

- “Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 30-50% үнэлгээтэй 10 арга хэмжээ байна.

*Журмын 6 дугаар бүлгийн 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалын дагуу* ***арга хэмжээний хүрсэн түвшинг хүрэх түвшинд харьцуулан хувиар илэрхийлбэл:***

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА /арга хэмжээгээр/

2023.06.14 Дархан-Уул аймаг

| № | Бүлэг / Үнэлгээ | | Бүгд | Бүлэг, үнэлгээ: I. Хүний хөгжлийн бодлого | II. Эдийн засгийн бодлого | IV. Ногоон хөгжлийн бодлого | V. Орон нутгийн хөгжлийн бодлого |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Зорилгын тоо | | **7** | **3** | **2** | **1** | **1** |
| 2. | Арга хэмжээний тоо | | **23** | **10** | **3** | **7** | **3** |
| 3. | Үнэлгээ | 100.0% | **7** | 5 | - | 2 | - |
| | | 90.0% | **1** | 1 | - | - | - |
| | | 70.0% | **5** | 1 | 1 | - | 3 |
| | | 50.0% | **3** | 1 | 2 | - | - |
| | | 30.0% | **7** | 2 | - | 5 | - |
| **Хэрэгжилтийн дундаж хувь, оноо** | | | **65.22% буюу 3.26 оноо** | **77.0% буюу 3.85 оноо** | **56.66% буюу 2.83 оноо** | **50.0% буюу 2.5 оноо** | **70.0% буюу 3.5 оноо** |

Журмын 6.2.3-д заасны дагуу зорилт, арга хэмжээний дундаж үнэлгээгээр бодлогын зорилго, зорилтын хэрэгжилтийг 4 ангилалд шилжүүлэн тооцоход 7 зорилгын дундаж үнэлгээ **59.52%** буюу **2.97** оноогоор үнэлэгдлээ.

### МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА / зорилгоор/

2023.06.14 Дархан-Уул аймаг

| № | Бүлэг / Үнэлгээ | | Бүгд | Бүлэг, үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | I. Хүний хөгжлийн бодлого | II. Эдийн засгийн бодлого | IV. Ногоон хөгжлийн бодлого | V. Орон нутгийн хөгжлийн бодлого |
| 1. | Зорилгын тоо | | **7** | 3 | 2 | 1 | 1 |
| 2. | Үүнээс | 100.0% | - | - | - | - | - |
| | | 70-99.0% | 6 | 2 | 2 | 1 | 1 |
| | | 30-69.0% | 1 | 1 | - | - | - |
| | | 0-29.0% | - | - | - | - | - |
| **Хэрэгжилтийн дундаж хувь, оноо** | | | **59.52% буюу 2.97 оноо** | **63.09% буюу 3.15 оноо** | **55.0% буюу 2.75 оноо** | **50.0% буюу 2.5 оноо** | **70.0% буюу 3.5 оноо** |

***Дөрөв. Цаашид анхаарах асуудал (Зөвлөмж)***

30%-ийн үнэлгээтэй 7 арга хэмжээний хувьд:

- Арга хэмжээ 1.1.6.5-ийн хувьд "шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангах цэцэрлэг, сургууль, дотуур байрны тоо"-г тодорхой тусгаж тайлагнах шаардлагатай. Хэдэн сургууль, цэцэрлэг, дотуур байр шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан нь тодорхойгүй, ерөнхий байдлаар тусгасан байна.
- Арга хэмжээ 1.3.2.8-ийн хувьд өнөөгийн нөхцөл байдлыг тусгасны зэрэгцээ тухай арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын 2024 оны төсвийн хөрөнгө оруулалтын төсвийн төсөлд 3 өрхийн

эмнэлгийн өргөтгөл барих саналыг Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн буюу бэлтгэл ажил хийгдсэн байна.

- Арга хэмжээ 4.1.1.2-ийн хувьд 7 сараас ойн хөнөөлт шавж, өвчний голомттой тэмцэх судалгааны ажил эхлэхээр бэлтгэл хангасан,
- Арга хэмжээ 4.1.1.3-ийн хувьд ойн зохион байгуулалт хийгдэхээр тендер шалгаруулалтын ажил явагдаж байгаа,
- Араг хэмжээ 4.1.1.4-ийн хувьд "Иргэдийн индэр" нээлттэй хэлэлцүүлгээс гарсан саналын дагуу аймгийн хэмжээнд ойд арчилгаа, цэвэрлэгээний ажлаар хэрэглээний мод бэлтгэлийн ажлыг аймгийн Засаг дарга 5 жилийн хугацаанд хориглосон шийдвэр гаргасантай холбоотой үйл ажиллагааг зогсоосон,
- Араг хэмжээ 4.1.3-ийн хувьд нөхөн сэргээх ажлыг гүйцэтгүүлэхээр аймгийн БОАЖГ-аас 4 удаа тендэр зарласан боловч 1 оролцогчоос төсөвт өртгөөс 47 хувиар илүү үнийн санал ирж шаардлага хангаагүй,
- Арга хэмжээ 4.1.4 –ийн хувьд Цөлжилтийг сааруулах, элсний нүүлтээс хамгаалах, хамгаалалтын зурвасыг 16 га талбайд хийхээс 4 га талбайд хийсэн байгаа нь тухай арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажлууд дууссан, боловсруулалтын шатанд байгаа гэж үзэн 30.0%-иар үнэллээ.

Цаашид хэрэгжилттэй уялдаж, үнэлгээний хувь нэмэгдэх боломжтой.

ТАНИЛЦСАН:
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА Б.АЗЖАРГАЛ

ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА П.БАЯРСАЙХАН

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН О.МӨНХСҮРЭН